



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 1/249

Номгон

Г Хаврын бүсийн хурдан морины 7
уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 27.6, 27.7, 27.10, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Хонгорын хурд" морин спорт уяачдын холбооны хүсэлтийг харгалзан Говийн бүсийн уралдааныг Баянлиг суманд 05 дугаар сарын 04-ний өдөр, Жинст суманд 05 дугаар сарын 03-ны өдөр, Төвийн бүсийн уралдааныг Эрдэнэцогт суманд 05 дугаар сарын 04-ний өдөр, Баян-Овоо суманд 05 дугаар сарын 01-ний өдөр, Хангайн бүсийн уралдааныг Жаргалант суманд 2026 оны 05 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уяач уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, даатгалд хяналт тавьж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар (Н.Мэндбаяр), Цагдаагийн газар (Т.Цэвээндорж), эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагва-Очир), уралдааныг зохион байгуулахад мэргэжил, арга зүй зөвлөгөө өгч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (М.Эрхэмбаяр), Биеийн тамир, спортын газар (Б.Хүрэлчулуун) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үндэсний өв соёл, үндэсний спортын ач холбогдол, үнэ цэнэ, уяачид, уралдаанч хүүхдүүдийг олон нийтэд сурталчлан таниулж, ард иргэдэд мэдээлэл түгээхийг Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (Б.Пүрэвдагва), Биеийн тамир, спортын газар (Б.Хүрэлчулуун) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010663